



4.1 Монгол орны байгалийн нөхцөл, нөөц

4-Р БҮЛЭГ.

Хичээлийн зорилго:

1. Стратегийн ашигт малтмалын орд, түүний нийгэм-эдийн засгийн ач холбогдлыг тодорхойлох.
2. Зурагзүйн дүрслэлийн аргыг хэрэглэх.

Хичээлийн зорилт:

1. Стратегийн ашигт малтмалын 5 том ордтой танилцах.
2. Кейс: Таван толгойн орттой танилцаж одоо ашиглагдаж байгаа нөөц дээр ЭЗ-н дүгнэлт өгөх.
3. Дасгалын зурагт тэмдэгтийн аргыг хэрэглэх.

Байгалийн нөхцөл, нөөц.

БАЙГАЛИЙН НӨХЦӨЛ

Газрын гадарга, геологийн тогтоц, уур амьсгал, ус зүй, хөрс, ургамал, амьтны аймаг зэргийг байгалийн нөхцөл гэнэ.



БАЙГАЛИЙН НӨӨЦ

Үйлдвэрлэлд шууд, тогтмол ашигладаг, байгалийн эрдэс, бодис, түүхий эд, эрчим хүчний эх үүсвэрийг байгалийн нөөц гэнэ.



Стратегийн ашигт малтмалын орд


Стратегийн ашигт малтмалын орд гэж үндэсний аюулгүй байдал, улсын болон бүс нутгийн эдийн засаг, нийгмийн хөгжилд нөлөөлөх хэмжээний, эсвэл жилд Монгол Улсын ДНБ-ний 5%-г үйлдвэрлэдэг, улсын ЭЗ, нийгмийн хөгжилд нөлөөлөх хэмжээний ордуудыг **стратегийн орд** гэнэ.

Ашигт малтмалын тухай хууль

СТРАТЕГИЙН АЧ ХОЛБОГДОЛТОЙ ОРД ГАЗРЫН НӨӨЦ, БАЯЛАГЫН ТӨРӨЛ

№	Орд газрын нэр	Нөөцийн тоо	Баялагын төрөл
1	Таван толгой	6 тэрбум тн	Нүүрс
2	Нарийн сухайт	91 сая тн	Нүүрс
3	Багануур	512.8 сая тн	Нүүрс
4	Шивээ овоо	564 сая тн	Нүүрс
5	Мардай	1104 тн	Уран
6	Дорнод	58933 тн	Уран
7	Гурванбулаг	16073 тн	Уран
8	Төмөртэй	229.3 сая тн	Төмрийн хүдэр
9	Оюу толгой	16 сая тн	Зэс
10	Оюу толгой	623 тн	Алт
11	Цагаан суврага	1.3 сая тн	Зэс
12	Цагаан суврага	43.6 мян тн	Молибден
13	Эрдэнэт	3.2 сая тн	Зэс
14	Эрдэнэт	90 мян тн	Молибден
15	Бүрэнхаан	40 сая тн	Фосфорит
16	Бороо	22 тн	Алт
17	Төмөртэйн овоо	820 мян тн	Цайр
18	Асгат	2247 тн	Жишмэл мөнгө

МОНГОЛ УЛСЫН СТРАТЕГИЙН АЧ ХОЛБОГДОЛ БУХНИЙ
АШИГТ МАТТМАЛЫН ОРДУУД



Даалгавар 1

1. Таван толгой-нүүрс
 2. Нарийн сухайт-нүүрс
 3. Төмөртэйн Овоо- цайр
 4. Бороо-алт
 5. Эрдэнэт- зэс, молибдени
1. Дараах 5 орд нь Улаанбаатар болон хамгийн ойр орших хилийн боомтоос хэдэн км зайд, ямар аймаг сумын нутагт оршиж байгааг google map-с олж байршлыг нь тогтооно уу.
 2. Ху 42 Кейс шинжилгээ. Дэлхийн зах зээл дэх ханшаар бодохоор жилд улсын төсөвт хэр их хэмжээний мөнгөн орлого оруулж байна вэ?
 3. Дасгалын зурагт эдгээр таван ордыг тэмдэгтийн аргаар байршуулна уу?

Дасгалын зураг

